

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоол



**НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 117

Улаанбаатар хот

**Орон нутгийн өмчит хуулийн этгээдийг  
өөрчлөн байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын "ж", Иргэний хуулийн 27 дугаар зүйлийн 27.3, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2015 оны 01/1919 дугаартай албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. "Амьдрах ухаан сургалт үйлдвэрлэлийн тусгай төв"-ийг "Нийгмийн хамгааллын тусгай төв" болгон өөрчлөн байгуулсугай
2. Өөрчлөн байгуулагдсан хуулийн этгээдийн дүрмийг хавсралтаар баталсугай.
3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Э.Бат-Үүп/-д даалгасугай.
  - 3.1. "Нийгмийн хамгааллын тусгай төв"-ийн бүтэц орон тооны хязгаарыг шинэчлэн баталж, өөрчлөн байгуулагдсан хуулийн этгээдийг улсын бүртгэлд шинэчлэн бүртгүүлэх ажлыг зохион байгуулах,
  - 3.2 Нийслэлийн Засаг даргын 2003 оны 417 дугаар захирамжаар батлагдсан "Амьдрах ухаан сургалт, үйлдвэрлэлийн тусгай төв"-ийн дүрмийг хүчингүй болгох.

Өмчтэйг  
 Өмчтэйг  
 Өмчтэйг

ТТБ-2105

ДАРГА



Д.БАТТУЛГА

Д.БАТТУЛГА

